



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

XXIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордон дахь “Нутгийн удирдлагын танхим”-д 7.6 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг вакцины 3 дахь тун хийх эсэх талаар судалгаа, нарийвчилсан төлөвлөгөө

ХӨСҮТ-ийн захирал,
Л.Баттөр,

2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээнд ашиглаж буй эм, тариа, эмнэлгийн хэрэгслийг хангалт, нийлүүлэлт, эмнэлгийн тусламжийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөө, эмч, эмнэлгийн ажилтнуудыг дайчлан ажиллуулах шинэчилсэн төлөвлөгөөний талаар

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

3. Спортын уралдаан, тэмцээнийг үзэгчгүйгээр зохион байгуулах талаар

БТСУХ-ны Спортын бодлогын хэрэгжилтийн
хэлтсийн дарга О.Баттулга,

4. Авто тээврийн шалган нэвтрүүлэх цэгүүдэд хяналт шалгалт хийсэн талаар

ОБЕГ-ын дарга, УОК-ын орлогч дарга,
Хошууч генерал Г.Ариунбуян,

5. Намрын ургац хураалтын талаар

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн З.Мэндсайхан

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболдод:

1.1. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор зорилтот бүлгийн иргэдийг вакцины 3 дахь тунд хамруулахад шаардлагатай вакцины татан авалт, төлөвлөлтийг нарийвчлан зохион байгуулах;

1.2. Вакцины гурав дахь тунтай холбоотой шинжлэх ухааны судалгааны үр дүн аргачлалыг боловсруулж, 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор Улсын онцгой комисст танилцуулах;

1.3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын судалгаа шинжилгээнд шаардлагатай санхүүжилтийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

1.4. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээнд ашиглаж буй эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн хангалт, нийлүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

1.5. Аймаг, орон нутгийн эрүүл мэндийн төв, хөгжлийн төвүүдэд түшиглэн коронавируст халдвар /Ковид-19/-аар өвдөөд эдгэрсэн хүнд нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, энэ талаарх зөвлөмж, зөвлөгөө боловсруулж, олон нийтэд мэдээлэл өгөх;

1.6. Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн судалгаа, бэлэн байдлын төлөвлөгөөг аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр нарийвчлан гаргах;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга Б.Цэцэгсайхан нарт:

2.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эмчилгээ, оношлогоонд ашиглах эм, тариа, эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөцийг холбогдох хуульд заасан шаардлагын дагуу бүрдүүлэх;

2.2. Эмчилгээний өндөр идэвхи, үр дүнтэй эм, тарианы татан авалт, ханган нийлүүлэлтийг хийж, бүх шатны эрүүл мэндийн байгууллагад зохих нөөцийг бүрдүүлэх;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Б.Ганзориг, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал Н.Цогбадрах нарт:

3.1. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодоор нэвтрэх хүн, ачаа, тээврийн хэрэгслийн гадаргууг халдваргүйжүүлэх ажлын зөвлөмж, зааврыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах;

3.2. Мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу халдваргүйжүүлэлт хийх байгууламж барих, шаардагдах тоног төхөөрөмж, бодис, хөрөнгийг шийдвэрлэж, Сонгинохайрхан дүүргийн Эмээлт, Баруунтуруун, Хан-Уул дүүргийн Өлзийт, Чингэлтэй дүүргийн Гүнт, Налайх дүүргийн 4-р зэрлөг, Городок, Багануур дүүргийн Хэрлэн, Багахангай

дүүргийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодоор нэвтрэх хүн, ачаа тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:


5.1. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, танхимын хичээл, сургалт явуулахад коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэхэд шаардлагатай журам, зааврыг боловсруулж батлах, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэн санал дүгнэлтийг Улсын онцгой комиссын хуралдаанд танилцуулах;


Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Д.Загджав, Дотоод хэргийн их сургуулийн захирал П.Батбаатар, Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Т.Хэрүүга нарт:

6.1. Ургац хураалтад ажиллах хүн хүчний тооцоо, судалгааг нарийвчилан гаргах. Уг тооцоо судалгаанд үндэслэн цэргийн алба хаагч, оюутан, хөнгөн ялтай хүмүүжигч нарыг ургац хураалтад ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

6.2. Авто замын эвдрэл, гэмтлийг шалган тогтоож, ургац тээврээс өмнө засварын ажлыг дуусгах, холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор ургац тээвэрт авто болон төмөр замын тээвэр зохицуулалтын ажлыг зохион байгуулах;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА  С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА  Т.БАЯРХҮҮ